

## ДЭЛХИЙН УЛС ОРНУУД БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА БОДЛОГО

**Азкейн Еркеш\***

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажлаараа дэлхийн улс орнууд болон Монгол Улсын хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн чиг хандлага, хөгжлийн бодлогоо тодорхойлж буй байдал, Монгол Улсын өрсөлдөх чадварт сүүлийн жилүүдэд гарсан ахиц дэвшлийг судлан дүгнэж, цаашид Монгол улсын тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулах шилдэг бизнесийн загварыг бий болгон нутагшуулах шаардлагатай болох талаар тодорхой саналыг дэвшүүллээ. Одоогоор дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн улс орнуудын хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн төгс шийдэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал юм. НҮБ-ын олон улсын тогтвортой хөгжлийн дэд хэмжээний чуулга уулзалт 1972 оноос хойш 20 жилийн давтамжтайгаар 1992 ба 2012 онуудад зохион байгуулагдаж, НҮБ-ын гишүүн орнуудын тогтвортой хөгжлийн суурь зарчим, хөтөлбөрүүдийг баталсан.

Монгол Улс 1992 онд НҮБ-ын “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтад оролцож, НҮБ-ын гишүүн орнуудын тогтвортой хөгжлийн нийтлэг чиг хандлагыг удирдлага болгон цаашид хөгжих замыг сонгосон. Монгол Улс 1996 оноос эхлэн НҮБ-ын гишүүн орнуудын жишгээр урт хугацааны хөгжлийн бодлогоо хэрэгжүүлээд 20 гаруй жил болж байгаа хэдий ч хөгжлийн түвшин нилээн доогуур байгаа нь дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан бэлтгэдэг дэлхийн хэмжээний судалгааны тайлангуудаас харагдаж байна.

Мөн цаашид манай улс өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд тулд макро болон микро аль аль түвшинд инноваци ба засаглалын сайн тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэртэй хөгжилд түүний оруулах хувь нэмрийг дээшлүүлэх шаардлагатай болохыг эдгээр

---

\*МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) yerkyesh2015@gmail.com

судалгааны тайлангууд харуулж байна.

**Түлхүүр үг:** Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, ногоон эдийн засаг, өрсөлдөх чадвар, шилдэг бизнесийн загвар

## Оршил

Одоогоор дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн улс орнуудын хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн төгс шийдэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь ХХ зууны 70-аад оны эхээр үүссэн. Энэ үзэл баримтлал нь тухайн үеийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудад хамаарах Римийн клубын үйл ажиллагаа, 1972 онд НҮБ-аас олон улсын тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулсан “Хүн төрөлхтөн ба Байгаль орчин” анхны чуулга уулзалт, түүнээс гаргасан тунхаглалаас эхтэй. Римийн клуб нь 1968 онд Рим хотод Дей Линчейгийн академийн дэргэд байгуулагдсан ба энэ клубын гишүүнээр дэлхийн хамгийн нөлөө бүхий өндөр хөгжилтэй орнуудын 100-аас доошгүй, нэртэй эрдэмтэд сонгогддог байсан. Клубын үндсэн үйл ажиллагаа нь дэлхий нийтийг хамарсан томоохон асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулан зөвлөмж санал гаргах ажил байв.

Тогтвортой хөгжлийг тодорхойлсон олон тодорхойлолтууд байдаг. Эдгээр тодорхойлолтуудаас 1987 онд Брундланд (Brundtland)-ын тэргүүлсэн Дэлхийн байгаль орчин, хөгжлийн хорооны тайланд орсон дараах тодорхойлолтыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг:

*“Тогтвортой хөгжил гэж хойч үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр одоогийн хэрэгцээ шаардлагыг хангах хөгжил юм”*

Тогтвортой хэмээх үг нь хүний амьдралын чанар, хүн төрөлхтний эв нэгдэл, шударга зарчим, байгаль орчны хамгааллыг эрхэмлэсэн шинэ үнэлэмжинд тулгуурласан хөгжлийн загварыг илэрхийлдэг.<sup>2</sup> Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжил гэж байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт хөгжлийг хангахыг хэлнэ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь байгаль, нийгмийн хөгжлийн зүй тогтолд нийцүүлэн эдийн засгийг хөгжүүлэхэд оршино. Аливаа байгалийн нөөцийг ашиглахаас өмнө түүнийг ашигласнаар улс орны эдийн засагт оруулах үр ашиг, нийгэмд үзүүлэх хувь нэмэр, байгаль орчинд нөлөөлөх байдлыг 2 Азийн сан (2015) “Тогтвортой хөгжил –байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт, хуу 12

шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сайтар тооцон үзэж шийдвэрлэх нь тогтвортой хөгжлийн эхний алхам юм.

### **Дэлхийн улс орнуудын хөгжлийн бодлого**

НҮБ-ын олон улсын тогтвортой хөгжлийн дэд хэмжээний чуулга уулзалт 1972 оноос хойш 20 жилийн давтамжтайгаар 1992 ба 2012 онуудад тус тус зохион байгуулагдаж, дэлхий нийтэд тулгамдаад байгаа асуудлыг хэлэлцэж нэгдсэн шийдэлд хүрсэн. Үүнд:

- ✓ 1972 оны “Хүн төрөлхтөн ба Байгаль орчин” сэдэвт чуулга уулзалтаар олон улсын хэмжээнд баримтлах тогтвортой хөгжлийн тунхаглал болон хүрээлэн буй орчны хөгжлийн зарчмуудыг баталсан байна.
- ✓ 1992 оны “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт чуулга уулзалтаар олон улсын тогтвортой хөгжлийн үндсэн зарчмууд, 21 зууны тогтвортой хөгжлийн стратеги (Agenda 21)-ийг баталсан ба НҮБ-ын гишүүн орон бүр өөрсдийн 21 зууны тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан. Эдгээр тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудыг улс орнууд хөгжлийн гол загвар, зарчим болгон мөрдөж эхэлсэн.
- ✓ 2012 оны “Тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгах ногоон эдийн засаг” ба “Тогтвортой хөгжил дэх засаглалын хүрээ” сэдэвт чуулга уулзалтаар 2000 онд Нью-Йорк хотод Дэлхийн улс орнуудын удирдагчдын уулзалтаас баталсан Мянганы хөгжлийн зорилтуудаас хэрхэн тогтвортой хөгжлийн зорилтуудад шилжих талаар тодорхой шийдэлд хүрээгүй ч цаашид тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах санаачлагыг гарган, тогтвортой хөгжилд хүрэх нэг арга зам нь ногоон эдийн засаг болохыг оролцогчид бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн ба тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах чухал арга хэрэгсэл болох ногоон эдийн засгийг улс орон бүр өөрийн үндэсний онцлогт тохируулан хөгжүүлэхийг зөвлөсөн юм. Улмаар НҮБ-ын төрөлжсөн байгууллагаас байгалийн нөөцийг үр ашигтай ашиглаж орчны бохирдол, доройтлоос зайлсхийх, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтолцоог бий болгож хөгжүүлэхэд чиглэсэн ногоон хөгжил, ногоон эдийн засаг, ногоон үйлдвэрлэл, ногоон өсөлтийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн. “Ногоон хөгжил” гэж байгалийн нөөцийг хэмнэлтэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг, “ногоон эдийн засаг” гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал,

нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг хэлнэ.

2015 оны 09 дүгээр сард НҮБ-ээс батлан гаргасан 2030 он хүртэл хэрэгжүүлэх “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” /“Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development”/ нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дууссан “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг нөхөн гарч ирж буй шинэ хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь 2030 он хүртэл хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, сайжруулах, байгаль орчныг хамгаалах асуудлыг цогц байдлаар авч үзэн дэлхийн түвшинд томъёолсон. НҮБ дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг ядуурал, орлогын ялгаатай байдлыг арилгах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжин, хүнсний тэжээлээг чанар, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, өлсгөлөнг зогсоох, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох, эрчим хүч, дэд бүтцийн хангамжийг сайжруулах, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох, дэлхийн хэмжээнд тулгарч байгаа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, улмаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар дэлхийн дулаарлыг сааруулах зэргээр тодорхойлсон.

Дэлхийн улс орнууд урт хугацааны хөгжлийн бодлогоо дунджаар 15-20 жилийн хугацаатайгаар төлөвлөж, үр дүн буюу гүйцэтгэлд суурилсан удирдлагыг ашиглан хэрэгжүүлж байна. Жишээ нь:

- ✓ Европын Холбооны гишүүн орнууд 2010 онд “Европ 2020: Ухаалаг, тогтвортой, хүртээмжтэй өсөлт” нэртэй урт хугацааны бодлого,
- ✓ Оросын Холбооны улс 2008 онд “ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”,
- ✓ Хятад улс 2013 онд “Хятад 2030” урт хугацааны бодлогыг тус тус боловсруулан хэрэгжүүлсэн байна.

### **Монгол Улсын хөгжлийн бодлого ба өнөөгийн байдал**

Монгол Улсын хөгжлийн бодлого

1992 оны НҮБ-ын “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын ерөнхий сайд Л.Бямбасүрэн тэргүүтэй төлөөлөгчид оролцон НҮБ-ын гишүүн орнуудын тогтвортой хөгжлийн нийтлэг чиг хандлагыг удирдлага болгон цаашид хөгжих замыг сонгосон. Тус чуулга уулзалтаар НҮБ-ын гишүүн орон бүр өөрсдийн 21 зууны тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс НҮБ-ын гишүүн орнуудын тогтвортой хөгжлийн

зарчимд үндэслэн урт хугацааны хөгжлийн бодлогоо 3 удаа баталсан. Үүнд:

- ✓ 1996 онд 1996-2020 онуудад хэрэгжих “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал”,
- ✓ 2008 онд 2007-2021 онуудад хэрэгжих “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”,
- ✓ 2016 онд 2016-2030 онуудад хэрэгжих “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн өнөөгийн байдал

Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан бэлтгэдэг судалгааны тайланд манай улсын өрсөлдөх чадварын эрэмбэ дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төвийн тайланд Монгол Улс 2015 оноос эхэлж орсон. 2015 онд Монгол Улс судалгаанд хамрагдсан 61 орноос өрсөлдөх чадвараараа 57 дугаарт<sup>3</sup>, 2016 онд 2015 оноос 3 байраар ухарч 61 орноос 60 дугаарт<sup>4</sup> эрэмблэгдсэн байна.
- ✓ Дэлхийн эдийн засгийн форумын судалгаанд Монгол Улс 2005 оноос хойш хамрагдсан бөгөөд 2014-2015 оны тайланд судалгаанд оролцсон 144 орноос өрсөлдөх чадвараараа 98 дугаарт, 2015-2016 оны тайланд 140 орноос 104 дүгээр байрт, 2016-2017 оны тайланд 138 орноос 102 дугаарт тус тус жагссан байна.<sup>5</sup>

Дээрх судалгаанууд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өрсөлдөх чадварын индексийг ашиглан улс орнуудыг байр эзлүүлдэг. Энэ индекс нь дэлхийн хөгжлийн чиг хандлагыг даган тухайн улс орнуудын тогтвортой хөгжлийн хүрсэн түвшинг илэрхийлэх шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээнд үндэслэдэг. Өрсөлдөх чадварын судалгааны тайлангуудыг улс орнууд хөгжлийн бодлогоо тодорхойлоход харгалзан үздэг. Тухайлбал, “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д “Дэлхийн эдийн засгийн форумын судалгаагаар Монгол улсын өнөөгийн хүрсэн түвшинг урагшлуулж, дэлхийд өрсөлдөх чадвар сайтай 70 орны нэг болох” зорилт дэвшүүлсэн. Өрсөлдөх чадварын индексийг тооцоход Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төв нь эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагуудын ашигт ажиллагаа болон дэд бүтэц гэсэн 4 үндсэн бүлгийн 340 гаруй шалгуур

3 <http://www.imd.org/wcc/news-wcy-ranking/IMD World Competitiveness Rankings 2015>

4 [http://www.icegec.hu/download/publications/imd\\_2016\\_eng.pdf](http://www.icegec.hu/download/publications/imd_2016_eng.pdf)

5 World Economic Forum: The Global Competitiveness Report 2014-2015, p13

World Economic Forum: The Global Competitiveness Report 2015-2016, p7

World Economic Forum: The Global Competitiveness Report 2016-2017, p13

үзүүлэлтийг, Дэлхийн эдийн засгийн форум нь институцийн тогтолцоо, дэд бүтэц, макро эдийн засгийн тогтвортой байдал, эрүүл мэнд ба суурь боловсрол, дэд боловсрол ба мэргэжлийн сургалт, бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, технологийн бэлэн байдал, зах зээлийн хэмжээ, бизнесийн боловсронгуй байдал, инноваци гэсэн 12 бүлэг, 103 шалгуур үзүүлэлтэд үндэслэдэг. Өөрөөр хэлбэл, тайлан тус бүр нь өрсөлдөх чадварын индексийг тооцоход улс орнуудын өрсөлдөх чадварыг бүхий л талаас нь харуулах олон шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг учраас аль нэг үзүүлэлтийн үнэлгээний ерөнхий дүнд үзүүлэх нөлөө туйлын бага буюу хязгаарлагдмал гэж хэлж болно. Дэлхийн эдийн засгийн форумын 2016-2017 оны тайлангаас харахад Монгол Улсын өрсөлдөх чадварт өнгөрсөн онуудтай харьцуулахад ахиц гарсангүй. Ер нь энэхүү судалгаанд хамрагдсан өнгөрсөн 12 жилийн хугацаанд манай улс өрсөлдөх чадварын ерөнхий индексийн авбал зохих 7 онооноос 3.2-3.9 оноо буюу дөнгөж талаас илүү хувийг авсан нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Уг тайлангаас үзэхэд макро эдийн засгийн орчин, институцийн чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, бизнесийн боловсронгуй байдал, зах зээлийн хэмжээ, инноваци зэрэг хүчин зүйлс манай улсын өрсөлдөх чадварыг хойш нь татаж байна.

Мөн Улаанбаатар хот агаарын бохирдлоор дэлхийд тэргүүлж, усны бохирдол, газрын доройтол хэтэрсэн тул байгаль орчин ч тогворгүй болсон. Жишээ нь: Улаанбаатар хот агаарын бохирдлоор дэлхийд 2014 онд 3 байр, 2015 онд 7 байр, 2016 онд 3 байрт байна. Олборлох салбар болон мал аж ахуйгаас хэт хамааралтай эдийн засгийн эмзэг бүтэц, ядуурлын түвшин, орлогын тэгш бус хуваарилалт, техник, технологийн хоцрогдол, эмнэлэг ба ерөнхий боловсролын үйлчилгээний хүрэлцээгүй байдал зэрэг нь манай улсын сул тал болж байна.

### **Дүгнэлт, санал**

Одоогоор дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн улс орнуудын хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн төгс шийдэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал юм. 1972 оноос хойш дэлхийн улс орнуудын тогтвортой хөгжлийн бодлогын суурь зарчмыг НҮБ-ын олон улсын тогтвортой хөгжлийн дэд хэмжээний чуулга уулзалтуудаар баталж ирсэн. НҮБ-ын гишүүн орнуудад одоо хэрэгжиж буй 2030 он хүртэл үргэлжлэх хөгжлийн бодлого нь үндсэндээ 2015 оны 09 дүгээр сард НҮБ-ээс батлан гаргасан “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой

хөгжлийн хөтөлбөр-2030” /“Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development”/-ийн үзэл баримтлалтай нийцсэн. Энэхүү хөтөлбөр нь 2030 он хүртэл хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, сайжруулах, байгаль орчныг хамгаалах асуудлыг цогц байдлаар авч үзэн дэлхийн түвшинд томъёолсон.

Монгол Улс 1992 оноос эхлэн НҮБ-ын гишүүн орнуудын тогтвортой хөгжлийн нийтлэг чиг хандлагыг удирдлага болгон цаашид хөгжих замыг сонгосон ба 1996 оноос эхлэн НҮБ-ын гишүүн орнуудын жишигт нийцүүлэн урт хугацааны хөгжлийн бодлогоо 3 удаа баталсан. Монгол Улс дэлхийн бусад орнуудын жишгээр урт хугацааны хөгжлийн бодлогоо хэрэгжүүлээд 20 гаруй жил болж байгаа хэдий ч хөгжил нь нилээн доогуур байгаа нь дэлхийн хэмжээний судалгааны тайлангуудаас харагдаж байна. Мөн эдгээр тайлангууд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын өрсөлдөх чадварт дорвитой ахиц гараагүй, үүнд макро эдийн засгийн орчин, институцийн чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, бизнесийн боловсронгуй байдал, зах зээлийн хэмжээ, инноваци зэрэг олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлсөөр байгааг баталж байна.

Эдгээр нөхцөл байдлыг сайтар судлан үзэхэд манай улс өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд макро болон микро аль аль түвшинд инноваци ба засаглалын сайн тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэртэй хөгжилд түүний оруулах хувь нэмрийг дээшлүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Өрсөлдөх чадвар сайтай, хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнуудын туршлагаас харахад микро түвшинд тогтвортой хөгжлийн 3 тулгуур эдийн засаг, байгаль орчин, нийгмийн шалгуур үзүүлэлтүүдэд тэнцвэртэй ач холбогдол өгч байгууллагын гүйцэтгэлийг үнэлж тогтвортой хөгжилд чиглүүлдэг болох нь харагдаж байна.

Иймд цаашид компанийн хөгжлийг хамгийн төгс хэлбэрээр чиглүүлдэг, улс орны эдийн засагт бодит өсөлтийг бий болгодог Балдрижийн загвар, Европын бизнесийн загвар гэх мэт шилдэг бизнесийн загваруудыг судлан үндэсний компаниудын онцлогт нийцүүлэн өөрчлөн нутагшуулах шаардлагатай байна.

### Ашигласан материал

- The Global Innovation Index 2015. Effective innovation Policies for Development, Johnson Cornell University, Instead: The Business School for the World, World Intellectual Property Organization
- IMD World Competitiveness Yearbook 2015
- IMD World Competitiveness Yearbook 2016
- World Economic Forum: The Global Competitiveness Report 2014-2015  
[http://www3.weforum.org/docs/WEF\\_GlobalCompetitivenessReport\\_2014-15.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GlobalCompetitivenessReport_2014-15.pdf)
- World Economic Forum: The Global Competitiveness Report 2015-2016  
[http://www3.weforum.org/docs/gcr/2015-016/Global\\_Competitiveness\\_Report\\_2015-2016.pdf](http://www3.weforum.org/docs/gcr/2015-016/Global_Competitiveness_Report_2015-2016.pdf)
- World Economic Forum: The Global Competitiveness Report 2016-2017  
[http://www3.weforum.org/docs/GCR2016-2017/05FullReport/TheGlobalCompetitivenessReport2016-2017\\_FINAL.pdf](http://www3.weforum.org/docs/GCR2016-2017/05FullReport/TheGlobalCompetitivenessReport2016-2017_FINAL.pdf)
- Mongolian Economic Policy and Competitiveness Research center: Mongolian Competitiveness Report 2013, 31-32
- Сангийн сайдын 2013 оны 277 тоот тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 он
- Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, 2014 он
- Конрад –Аденауэр сан, Иргэний зориг ногоон нам (2014), “Ногоон хөгжил”  
[http://www.kas.de/wf/doc/kas\\_40970-1522-18-30.pdf?150724075810](http://www.kas.de/wf/doc/kas_40970-1522-18-30.pdf?150724075810)
- Монгол Улсын Засгийн газар, RIO +20 United Nations Conference on Sustainable Development, UNDP Mongolia (2012) “Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго
- Азийн хөгжлийн сан (2015) “Тогтвортой хөгжил-байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт”, <http://esec.mn/backend/f/0QccCuNqEr.pdf>